Санхүү, үйл ажиллагааны гүйцэтгэлийн товч танилцуулга – 2022 оны 3-р улирал

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК
MSE: CUMN

2022 оны 12-р сарын 05

Стратегийн зорилго

	2019	2020	2021	2022	2023
Дэлгүүрийн тоо	56	103	165	**285**	360
Цэвэр орлого, төгрөг	37 тб	45 тб	94.2 тб	**238 тэрбум**	390 тэрбум
Цэвэр алдагдал	(11.3 тб)	(15.7 тб)	(18.1 тб)	(12.1) тб	7.7 тб
Боломжит татварын хөнгөлөлт	+0.0	+1.14	+1.24		

	Стратеги	
1	Зах зээлд манлайлах	360 дэлгүүрийг шилдэг байршилд нээх
2	Дэд бүтэц	Түгээлтийн төв, хоол үйлдвэрлэлийн төв, мэдээллийн технологийн дэд бүтцийн хүчин чадал, үр ашгийг нэмэгдүүлэх
3	Бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгарал	Трэнди бүтээгдэхүүн, үйлчилгээгээр зах зээлээ тэргүүлэх
4	Үнэнч хэрэглэгчдийг нэмэгдүүлэх	Чанар, үйлчилгээний стандартыг өндөрт барьж үнэнч хэрэглэгчдийг урамшуулах
5	Технологийн дэвшлийг нэвтрүүлэх	CU app, Финтек болон дижитал шийдлүүдээр дамжуулж шинэ үнэ цэнийг бүтээх

2022 оны 3-р улирлын онцлох зүйлс

- **Цэвэр орлого 72.8 тэрбум ₮**
  - Төлөвлөгөөг **+8.0%** давуулсан
- **Цэвэр ашиг(алдагдал): (4.5) тэрбум ₮**
  - Төлөвлөгөөнөөс **3.3 тэрбум ₮ –р их**
- **Харьцуулагдах дэлгүүрийн** борлуулалт өмнөх оны мөн үетэй харьцуулахад: **+97.5% өссөн**
  - Үйлчлүүлэгчдийн тоо +7.6%, дундаж сагсны үнэ +24% өссөн
- **Шинээр +29 дэлгүүр** нээсэн

Орлого, үр дүнгийн гол үзүүлэлт

Тэрбум төгрөг.

	22Q1		22Q2		22Q3		22Q3 YTD		
		YoY		YoY		YoY		YoY	vs. Plan
Системийн борлуулалт (НӨАТ-тэй)	**47.3**	**+253%**	**78.5**	**+244%**	**81.7**	**+171%**	**207.5**	**+213%**	+12%
Цэвэр орлого	**41.6**	+246%	**69.6**	+242%	**72.8**	+176%	**184.0**	+213%	+9%
Нийт ашиг (алдагдал)	**-1**	+47%	**1.6**	+184%	**1.6**	+376%	**2.1**	+149%	-63%
Нийт ашгийн (алдагдлын) хувь	**-2.40%**	+13.4%	**2.30%**	+11.6%	**2.15%**	+4.31%	**1.16%**	+8.58%	-66%
Цэвэр алдагдал	**-5.8**	-41%	**-1.3**	+70%	**-4.5**	-58%	**-11.6**	-2.8%	-36%

Үйл ажиллагаа, цар хүрээ

	2022Q3	YoY%	2022H1	2022Q1	FY2021
Салбар дэлгүүрийн тоо	257	+90%	228	197	165
Үйлчлүүлэгчдийн тоо	24.1 сая+	+187%	14.8 сая+	5.6 сая+	13.4 сая+
Ажилтны тоо	3,200+	+129%	2,800+	2,400+	1,600+
Вендорын тоо	320+	-	520+	410+	400+
Хувьцаа эзэмшигчдийн тоо	10,073	-	9,638	9,479	9,546

Санхүүгийн байдлын тайлангийн гол үзүүлэлт

Тэрбум төгрөг.

Хөрөнгө (гол үзүүлэлтүүд)	2021Q4	2022Q3	Өөрчлөлт₮
Эргэлтийн хөрөнгө	40.8	49.7	+8.9
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	4.1	5.7	+1.6
Борлуулах зорилгоор эзэмшиж буй үнэт цаас ба зээл	16.8	0.1	-16.7
Бараа материал	14.0	30.9	+16.8
Эргэлтийн бус хөрөнгө	87.1	126.3	+39.2
Нийт хөрөнгө	127.8	176.0	+48.2

Өр төлбөр, эздийн өмч (гол үзүүлэлтүүд)	2021Q4	2022Q3	Өөрчлөлт₮
Нийт өр төлбөр	71.5	132.2	+60.7
Эргэлтийн өр төлбөр	30.0	55.2	+25.2
Худалдааны болон бусад өглөг	22.7	44.6	+21.9
Богино хугацаат зээл	2.0	3.5	+1.5
Эргэлтийн бус өр төлбөр	41.4	77.0	+35.5
Урт хугацаат зээл	14.4	25.2	+10.8
Урт хугацаат түрээсийн өглөг	27.0	51.7	+24.8
Нийт эздийн өмч	56.4	43.8	-12.6
Нийт өр ба эздийн өмч	127.8	176.0	+48.2

Мөнгөн гүйлгээний тайлангийн гол үзүүлэлтүүд (тохируулсан)



	2021Q1	2021Q2	2021Q3	2022Q3 YTD
Үйл ажиллагааны МГ	0.3	5.6	2.3	+8.1
Үйл ажиллагааны МГ (Түрээс тохируулсан)	(2.5)	2.1	(1.8)	(2.2)
Хөрөнгө оруулалтын МГ*	(7.8)	(9.0)	(8.3)	(25.0)
Чөлөөт мөнгөн урсгал	**(1.3)**	**1.1**	**(9.7)**	**(9.9)**
Санхүүгийн МГ	(0.3)	0.3	11.5	11.5
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	**2.5**	**3.9**	**5.7**	**5.7**

Харьцуулагдах дэлгүүрийн гүйцэтгэл (YoY%)



Харьцуулагдах дэлгүүрийн гүйцэтгэл – Өдрийн дундаж ашиг

Худалдааны салбар

	2021.01-09	2022.01-09	YoY%
Жижиглэнгийн худалдаа	12.0 их наяд ₮	15.7 их наяд ₮	+30.4%
Шатахууны жижиглэнгийн худалдаа	3.9 их наяд ₮	6.2 их наяд ₮	+60.3%
Шатахууны бус жижиглэнгийн худалдаа	**8.1 их наяд ₮**	**9.5 их наяд ₮**	**+17.3%**
Бодит ДНБ	19.5 их наяд ₮	20.3 их наяд ₮	+3.7%

	2021.Q3	2022.Q3	YoY%
Хүнсний бараа, ундаа, усны үнийн индекс	113.2	132.4	+17.0%
Өрхийн сарын дундаж бодит орлого	1,108,716	1,089,658	-1.7%
Өрхийн дундаж цалин хөлс	733,815	873,559	+19.0%

Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Анхаарал хандуулсанд баярлалаа

CU Again

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Хэнд: Санхүүгийн Зохицуулах Хороо (“Хороо”)
Хэнээс: Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)
Огноо: 2022-07-06
Гарчиг: Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт (шинэчилсэн)

Удиртгал

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10-р сарын 13-ны өдрийн 430 тоот тогтоолын дагуу:

- **Үндсэн тоо ширхэг**: 119,966,060 ширхэг энгийн хувьцааг тогтоосон үнийн аргаар нэг бүрийн үнийг 208 төгрөгөөр нийт олон нийтэд санал болгосон. Үндсэн тоо ширхэг нь 24,952,940,480 төгрөгийн үнийн дүнтэй байна.
- **Нэмэлт тоо ширхэг**: Мөн тус тогтоолын 9-т заасны дагуу анхдагч зах зээлийн арилжааны эрэлт нь нийлүүлэлтээс давсан тохиолдолд 17,994,909 ширхэг хүртэлх хувьцааг нэмж гаргах боломжтой байсан. Нэмэлт тоо ширхэг нь 3,742,941,072 төгрөгийн үнийн дүнтэй.
- **Нийт гаргасан тоо ширхэг**: Хөрөнгө оруулагчдын эрэлт нь үндсэн тоо ширхгээс 61%-иар давсан учраас Компани нь 137,960,969 ширхэг хувьцааг олон нийтэд арилжаалсан билээ. Нийт 28,695,881,552 төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөг бид үндсэн тоо ширхэг дээр тулгуурлан дараах байдлаар Үнэт цаасны танилцуулгад тусгасан билээ.

Зураг 1. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Хүснэгт 27. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

№	Хөрөнгө оруулалтын зориулалт	Үнийн дүн, сая төгрөг	Зарцуулалтад эзлэх хувь хэмжээ
1	Нэмэлт 95 дэлгүүрийн хөрөнгө оруулалт	19,000	76%
2	Түгээлтийн төвийн нэмэлт тоног төхөөрөмжийн худалдан авалт, суурилуулалт	2,950	12%
3	Хоол үйлдвэрлэлийн төвийн нэмэлт тоног төхөөрөмжийн худалдан авалт, суурилуулалт	3,003	12%
	Нийт татан төвлөрүүлэх хөрөнгө	24,953	100%

Хороо-ноос Компани дээр татан төвлөрүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх, мөн хууль, дүрэм журмын хэрэгжилтийн нийцтэй байдал дээр 2022 оны 5-р сарын 25-ны өдөр хяналт, шалгалтын үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд, Компани холбогдох бүх мэдээллийг цаг хугацаанд нь эмх цэгцтэй гарган өгч, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг 2022 оны 6-р сарын 6-нд цахимаар хүргүүлсэн. Бидний хүргүүлсэн тайлан дээр нийт гаргасан тоо ширхгээр тооцогдсон нийт татан төвлөрүүлсэн дүнгээс IPO үйл ажиллагаатай шууд холбогдох 1.69 тэрбум төгрөгийн зардлыг хасагдуулсан дүнгээс зарцуулалтыг төсөвлөн хүргэсэн. Уг тайлагнал нь СТОУС-ын дагуу эх үүсвэр татах үед түүнтэй шууд холбоотой зардлуудыг хасч бүртгэх зарчим дээр үндэслэсэн тооцоолол байсан бөгөөд энэхүү тодруулга мемогоор бид дээрх зардлуудыг хасагдуулалгүйгээр, зөвхөн МХБ, СЗХ, ҮЦТХТ-ийн арилжааны шимтгэлийг хасагдуулсан дүн буюу Компани дансандаа хүлээж авсан мөнгөн дээр үндэслэн залруулан хүргүүлж байна. Бид IPO-той холбогдох шууд зардлуудыг хасагдуулаагүй дүнтэй тэнцэх хөрөнгө оруулалтыг төлөвлөж зориулалтын дагуу зарцуулж байгааг та бүхэнд мэдэгдэж байна.

Өмнөх тайлангийн товч тайлбар. Компани нь үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үедээ Андеррайтер, Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хорооноос татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөлтийг IPO үйл ажиллагаатай холбоотой зардлыг хасагдуулсан эсвэл хасагдуулаагүй дүнгээс хийх эсэх дээр зөвлөмж авч байсан бөгөөд бид а) үнэт цаасны танилцуулгад нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүнгээс зарцуулалтыг төлөвлөөд, б)

зарцуулалтын тайлан дээр IPO зардлуудаа тусган хүргүүлдэг гэж ойлгосон билээ. Хавсралт №3-д харагдаж буй бүх IPO-ийн үнэт цаасны танилцуулга дээр тусгагдсан байгаа татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөний мэдээллээс харахад IPO-той холбоотой зардлыг тайланд тусгаагүй төлөвлөсөн байсан нь бидний хүлээн авсан дээрх ойлголтыг баталгаажуулж байсан юм. Тийм учраас бид андеррайтерын зөвлөмжийн дагуу үнэт цаасны танилцуулгад IPO үйл ажиллагаатай холбоотой төсөвлөсөн зардлуудыг тусгаагүй билээ. Харин татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлагналаар IPO-той холбоотой зардлуудыг тусган хүргүүлэх нь зүйтэй гэж үзсэн билээ.

Хүснэгт 1. IPO үйл ажиллагаатай холбоотой зардлууд.

IPO үйл ажиллагаатай холбоотой зардлууд	**1,690,369,152**
Үүнээс:	
Андеррайтерийн хураамж	1,046,068,218
Үнэт цаас бүртгэх үйлчилгээний хөлс	50,000,000
Үнэлгээний ажлын хөлс	60,000,000
ҮЦТХТ - хувьцаа нэр зааж бүртгүүлсэн	69,880,767
БОНЗ үнэлгээ - Ризиленс Консалтинг	28,267,175
Хууль зүйн зөвлөх үйлчилгээ	44,000,000
Маркетингийн үйл ажиллагаа ба бусад[1]	392,152,991

Маркетингийн үйл ажиллагаа ба бусад гэдэг хэсэгт ямар нэгэн цалин урамшуулалтай холбоотой зардал огт байхгүй бөгөөд, зөвхөн IPO-той холбоотой зардлууд багтсан. Дээрх зардлуудаас андеррайтерын хураамжийн зардлын дийлэнх хэсэг нь анхдагч зах зээлийн арилжааны дараагаар гарсан зардал болно. Бусад зардал нь өмнө гарсан байсан.

Зарцуулалтын шинэчилсэн төлөвлөгөө

Үнэт цаасны танилцуулгын 150-р нүүрэн дэх Хүснэгт 27-д заасанчлан татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө Зураг 1-д тусгагдсаны дагуу Үндсэн тоо ширхэг дээр суурилсан 24,952,940,480 төгрөгийн дүнтэй байсан. Бид СЗХ-ны тогтоолын дагуу нэмэлт тоо ширхгийг арилжаалах эрхээ ашигласан тохиолдолд зарцуулалт хэрхэн өөрчлөгдөхийг хөрөнгө оруулагчдад нэмэлт санхүүжилтийн цэвэр орлогоор дэлгүүрийн хөрөнгө оруулалт, мэдээллийн технологийн хөрөнгө оруулалт-д хийнэ гэж мэдэгдэж байсан.

Компанийн IPO амжилттай хэрэгжсэний дараагаар зохицуулагч байгууллага, арилжаа эрхлэгч байгууллагын зардал, хураамжийн дараах төвлөрүүлсэн хөрөнгийн цэвэр хэмжээ 28,535,184,615 төгрөг (Хүснэгт 2) байсан нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарцуулалтын төлөвлөсөн дүнгээс 3.58 тэрбум төгрөгөөр илүү байжээ. Үүнийг дээр дурьдсанчлан дэлгүүрийн хөрөнгө оруулалт болон мэдээллийн технологид хөрөнгө оруулалтанд зарцуулж байгаа бөгөөд 9-р сарын эцэст уг зарцуулалт бүрэн хийгдсэн байхаар төлөвлөж байна.

Хүснэгт 2. Бодитоор татан төвлөрүүлсэн хөрөнгө /суутгалын дараах дүн/

Гаргасан хувьцааны тоо	137,960,969
Нэгж хувьцааны үнэ	208
Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө	**28,695,881,552**
Суутгагдсан зардлууд	
МХБ арилжааны шимтгэл 0.4%	114,783,526
СЗХ арилжааны шимтгэл 0.04%	11,478,353
ҮЦТХТ арилжааны шимтгэл 0.12%	34,435,058
Компани дансандаа хүлээж авсан мөнгө	**28,535,184,615**

Зарцуулалтын гүйцэтгэл. Компани нь 2021 оны 9-р сарын сүүлээр IPO хийх төлөвлөгөөтэй байсан бөгөөд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг 10-р сараас хийхээр төлөвлөж байсан. Гэсэн хэдий ч IPO хийх ажил удаашран, 11-р сард санхүүжилт орж ирсэн тул Компани

[1] IPO үйл ажиллагаатай холбоотой зардлын задаргааг “3. IPO Expenses details.xlsx” файлаас харна уу.

хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс хоцрохгүйн тулд бусад эх үүсвэрээр санхүүжүүлэн, хөрөнгийн зарцуулалтыг 10-р сараас хуваарийн дагуу хийсэн.

2022 оны 5-р сарын 27-ны байдлаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг, хөрөнгө оруулалтын зориулалтаар ангилан Хүснэгт 3-т харуулав. Нийт төсөвлөсөн 28.5 тэрбум төгрөгийн зарцуулалтаас 22.6 тэрбум төгрөг буюу 79%-ийг зарцуулаад байна. Үүнээс дэлгүүрийн хөрөнгө оруулалтын зарцуулалт 91%, түгээлтийн төвийн хөрөнгө оруулалт 24%, хоол үйлдвэрлэлийн төвийн хөрөнгө оруулалт 46%-тай байна.

Хүснэгт 3. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт – 2022 оны 5-р сарын 27-ны байдлаар

Хөрөнгө оруулалт /сая ₮/	**Үнэт цаасны танилцуулга дахь төлөвлөгөө**	**Шинэчилсэн төлөвлөгөө**	**Зарцуулалт**	**Биелэлт**	**Үлдэгдэл**
Нэмэлт дэлгүүрийн хөрөнгө оруулалт	19,000	22,582	20,542	91%	2,040
Түгээлтийн төвийн хөрөнгө оруулалт	2,950	2,950	722	24%	2,228
Хоол үйлдвэрлэлийн төвийн хөрөнгө оруулалт	3,003	3,003	1,381	46%	1,622
Нийт	**24,953**	**28,535**	**22,646**	**79%**	**5,889**

Дэлгүүрийн хөрөнгө оруулалтын гүйлгээний задаргааг та бүхэнд хүргүүлсэн хавсралт файл “1. CAPEX - Store.xlsx”-ээс, Түгээлтийн төв болон хоол үйлдвэрлэлийн төвийн хөрөнгө оруулалтын гүйлгээний задаргааг хавсралт файл “2. CAPEX - FPC and DC.xlsx”-ээс харна уу.

Дээрх 5,889 сая төгрөгийн үлдэгдэл хөрөнгө оруулалтыг 2022 оны 9-р сард хийж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. Одоогоор хуваариас хоцорсон хөрөнгө оруулалт/бүтээн байгуулалт байхгүй.

1. Дэлгүүрийн хөрөнгө оруулалт

2021 оны 11-р сарын 12-нд бид 138 дэлгүүртэй байсан бол 2022 оны 6-р сарын 2-ны байдлаар бид 77 дэлгүүр нэмж нээн нийт 215 дэлгүүртэй болсон байна (Хүснэгт 4). Үүнээс гадна дараа дараагийн дэлгүүрүүдтэй холбоотой тоног төхөөрөмжүүдийг татан авсан байгаа ба агуулахад ойролцоогоор 35 дэлгүүрийн хөрөнгийн нөөцтэйгөөр дэлгүүр тэлэх үйл ажиллагаа хуваарьт төлөвлөгөөний дагуу амжилттай үргэлжилж байна.

Хүснэгт 4. Нээсэн ба нийт дэлгүүрийн тоо (сараар)

Сар	*Нээсэн дэлгүүр*	*Нийт дэлгүүр*
IPO хийхийн өмнө		138
2021 оны 11-р сар[2]	7	145
2021 оны 12-р сар	16	161
2022 оны 1-р сар	13	174
2022 оны 2-р сар	5	179
2022 оны 3-р сар	14	193
2022 оны 4-р сар	10	203
2022 оны 5-р сар	12	215

Мөн одоогийн байдлаар дэлгүүрийн хөрөнгө оруулалт бүрэн хийгдсэн ч бусад шалтгааны улмаас нээгдээгүй байгаа 3, нээхэд бэлэн болсон, бараа өрөлт хийж буй 1 дэлгүүр байна. Нээгдсэн дэлгүүрүүдийн жагсаалтыг **Error! Reference source not found.**-ээс харна уу.

2. Түгээлтийн төв, хоолны үйлдвэрийн хөрөнгө оруулалт

Түгээлтийн төвд 2.95 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт төсөвлөснөөс одоогоор 772 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн буюу төсөвлөгдсөн зарцуулалтын 24%-ийг гүйцэтгээд байна.

[2] 2021 оны 11-р сарын 12-оос хойш нээсэн дэлгүүрийн тоо.

Үлдсэн 2.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хуваарийн дагуу хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Хоол үйлдвэрлэлийн төвийн хувьд төсөвлөсөн 3.0 тэрбум төгрөгөөс 1.4 тэрбумыг буюу 46%-ийг зарцуулсан байна. Одоогоор 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө зарцуулалт үлдсэн байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэл

Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулагдаагүй дүн 4.2 тэрбум төгрөг байгаа ба үүнээс 3.7 тэрбум төгрөг нь харилцах дандсанд болон богино хугацаат үнэт цаасны хөрөнгө оруулалт хэлбэрээр хадгалагдаж байна. 0.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг бараа материалын нөөц татан төвлөрүүлэхэд ашигласан байна.

Хүснэгт 5. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэл - 2022 оны 5-р сарын 27-ны байдлаар

Хөрөнгийн үлдэгдэл	Дүн (сая ₮)
Мөнгөн хөрөнгө ба түргэн борлогдох үнэт цаас[3]	3,718
Бараа материалын нэмэлт нөөц	2,171
Нийт үлдэгдэл	**5,889**

1. Түргэн борлогдох үнэт цаасны хөрөнгө оруулалт

Компани богино хугацаанд буцаан худалдах гэрээний нөхцөлтэйгөөр үнэт цаасны хөрөнгө оруулалтуудыг хийсэн ба татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөт хугацаанд тохируулан богино хугацаат үнэт цаас худалдан авалт, борлуулалтыг гүйцэтгэсэн. Нийт 13 төрлийн үнэт цаасыг 19 тэрбум төгрөгөөр худалдан авсан ба эдгээрээс 11 үнэт цаасыг буцаан борлуулсан, 6-р сарын 6-ны өдрөөр 1.6 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий хоёр үнэт цаас эзэмшиж байжээ. Харин өнөөдөр буюу 6-р сарын 24-ны өдрөөр 100 орчим сая төгрөгийн үнэт цаас эзэмшиж байна.

2. Бараа материалын нэмэлт нөөц

Жижиглэн худалдааны бизнес эрхэлж буй манай Компанийн хувьд бараа материал нь хөрвөх чадвараар бэлэн мөнгөтэй дөхөхүйц эргэлтийн хөрөнгө юм. Учир нь бид зээлийн борлуулалтын үйл ажиллагаа зохион байгуулдаггүй. Компани Монгол улсад үүссэн хил гаалийн гацаа, ложистикийн хүндрэл бэрхшээлүүдээс хамаарч борлуулалтын орлогыг тасалдуулахгүй байх зорилгоор бараа материалын нэмэлт нөөцийг хэд хэдэн удаа үүсгэсэн.

2022 оны 5-р сарын байдлаар өдрийн дундаж борлуулалтын дүн 880 сая төгрөг байгаа ба одоогийн байдлаар бараа материалын нэмэлт нөөцийг санхүүжүүлэхэд ашигласан байгаа 2,171 сая төгрөгийн үлдэгдэл нь 2.5 өдрийн борлуулалттай тэнцэхүйц юм. Бид ложистикийн хүндрэл бэрхшээлийг зөв төлөвлөж бараа материалын нэмэлт нөөцийг бууруулах замаар дээрх хөрөнгийн үлдэгдлийг бэлэн мөнгө рүү суллаж хөрөнгө оруулалтаа үргэлжлүүлэх тодорхой төлөвлөгөөтэй ажиллаж бйана.

[3] Баталгаажсан үлдэгдлийг загварын дагуу тусдаа и-мэйлээр хүргүүлсэн.

Хавсралт №1

Хувьцааны үнийн хөдөлгөөн

CUMN хувьцааны үнийн өөрчлөлтийг ТОП 20 индексийн өөрчлөлттэй, хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш харьцуулан харахад ТОП 20 индекс 40,086.1-ээс 33,606.8 болж 16.2% буурсан бол CUMN хувьцааны үнэ 208 төгрөгөөс 200.1 төгрөг болж 3.8% буурчээ (Зураг 2).

CUMN хувьцааны үнийн өөрчлөлтийг ТОП 20 индекс болон APU, TUM, MFC хувьцаануудтай харьцуулсан тооцооллыг Зураг 3-т харуулав. Тооцооллыг хийхдээ харьцуулалтын зорилгоор 2022 оны эхэн үеэс харьцуулахад (2022 оны 1-р сарын 3) хувьцааны үнэ хэрхэн өөрчлөгдсөн байгааг индексжүүлэн оруулсан болно. Уг харьцуулалтаас харахад ТОП 20 индекс болон APU, TUM, MFC хувьцаануудын ханш буурах трендтэй харагдаж байна. Энэ нь макро эдийн засгийн нөхцөл байдал болон Монголын хөрөнгийн бирж дэх хувьцааны үнүүдийн улирлын мөчлөгийн нөлөөнөөс хамааралтай гэж үзэж байна. Зах зээл унах трендтэй уг үед CUMN хувьцааны ханш харьцангуй тогтвортой буюу үнээ сайн барьж байгаа нь харагдаж байна.

Зураг 2. CUMN болон TOP20 хөдөлгөөн /CUMN хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш/



Зураг 3. CUMN болон сонгосон хувьцаанууудын үнийн хөдөлгөөн /2022 оны эхнээс/



Хавсралт №2

Дэлгүүр тэлэлтийн мэдээлэл

№	Нэр	Салбарын дугаар	Нээгдэх өдөр	Төлөв	Тайлбар
1	Номуун хотхон	cu135	Тодорхойгүй	Нээгдээгүй	380 -ын техникийн нөхцөл хүлээгдэж байгаа
2	Блью жем	cu136	Тодорхойгүй	Нээгдээгүй	Зөвшөөрөл хүлээгдэж байгаа
3	Грейс төв	cu146	2021 оны 11-р сар	Нээгдсэн	
4	Нархан хотхон	cu148	2021 оны 11-р сар	Нээгдсэн	
5	Долоон буудал	cu149	2021 оны 11-р сар	Нээгдсэн	
6	Happy town	CU152	2021 оны 11-р сар	Нээгдсэн	
7	Food city	CU134	2021 оны 11-р сар	Нээгдсэн	
8	Сансарын тунел	CU154	2021 оны 11-р сар	Нээгдсэн	
9	ikh zasag	CU153	2021 оны 11-р сар	Нээгдсэн	
10	БГД 17-р хороо	CU155	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
11	Монгол хотхон	CU160	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
12	РЦНК	CU161	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
13	Хүрээ дээд	CU156	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
14	А үйлс хотхон	CU157	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
15	Japan town	CU159	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
16	Бум худалдааны төв	CU162	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
17	Астро Парк	CU163	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
18	ДИХС	CU164	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
19	Сувдан сондор	CU166	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
20	Гурван эрдэнэ	CU171	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
21	Авто плаза 2	CU167	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
22	Сансарын колонк	CU169	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
23	Тасганы овоо	CU168	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
24	Зүүн дөрвөн зам	CU170	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
25	ТТАХНЭ	CU119	2021 оны 12-р сар	Нээгдсэн	
26	Тэди-2	CU143	2022 оны 01-р сар	Нээгдсэн	
27	Евро таун	CU174	2022 оны 01-р сар	Нээгдсэн	
28	Дөлгөөн нуур	CU176	2022 оны 01-р сар	Нээгдсэн	
29	21 хороолол	CU151	2022 оны 01-р сар	Нээгдсэн	
30	Юү Би тауэр	CU150	2022 оны 01-р сар	Нээгдсэн	
31	САЦ зочид буудал	CU173	2022 оны 01-р сар	Нээгдсэн	
32	Комфорт хотхон	CU178	2022 оны 01-р сар	Нээгдсэн	
33	Хүннү плас	CU158	2022 оны 01-р сар	Нээгдсэн	
34	Энхжин худалдааны төв	CU181	2022 оны 01-р сар	Нээгдсэн	
35	Москва хороолол	CU179	2022 оны 01-р сар	Нээгдсэн	
36	Мандала хотхон	CU180	2022 оны 01-р сар	Нээгдсэн	
37	Удирдлагын. академи	CU184	2022 оны 01-р сар	Нээгдсэн	
38	Баруун 4 замын хойд	CU185	2022 оны 01-р сар	Нээгдсэн	
39	Дархан минж	CU186	2022 оны 02-р сар	Нээгдсэн	
40	Жуков худалдааны төв	CU187	2022 оны 02-р сар	Нээгдсэн	

№	Нэр	Салбарын дугаар	Нээгдэх өдөр	Төлөв	Тайлбар
41	Өргөө 2	CU194	2022 оны 02-р сар	Нээгдсэн	
42	Драгон	CU195	2022 оны 02-р сар	Нээгдсэн	
43	Хороолол	CU191	2022 оны 02-р сар	Нээгдсэн	
44	Вокзал	CU196	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
45	25-р суваг телевиз	CU182	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
46	Ахуй үйлчилгээний төв	CU188	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
47	Канион	CU198	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
48	Пийс молл-2	CU197	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
49	Гурван гал	CU192	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
50	Амарсанаагийн гудамж	CU190	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
51	МН Тауэр	CU193	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
52	Рома хотхон	CU199	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
53	Спортын ордон	CU189	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
54	Ард	CU203	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
55	Астра Плэйс	CU183	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
56	Саруул тэнгэр	CU201	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
57	Буянт ухаа-1	CU200	2022 оны 03-р сар	Нээгдсэн	
58	Соёмбот уул	CU175	2022 оны 04-р сар	Нээгдсэн	
59	Талын болор	CU205	2022 оны 04-р сар	Нээгдсэн	
60	Сансарын тойрог	CU133	2022 оны 04-р сар	Нээгдсэн	
61	Голомт хотхон	CU202	2022 оны 04-р сар	Нээгдсэн	
62	Блью жем	cu136	2022 оны 04-р сар	Нээгдсэн	
63	11-р сургууль	CU206	2022 оны 04-р сар	Нээгдсэн	
64	Кореа Таун	CU208	2022 оны 04-р сар	Нээгдсэн	
65	Бүти таун	CU209	2022 оны 04-р сар	Нээгдсэн	
66	Сүхбаатар нэгдсэн эмнэлэг	CU210	2022 оны 04-р сар	Нээгдсэн	
67	Номуун хотхон	cu135	2022 оны 04-р сар	Нээгдсэн	
68	Парк	CU211	2022 оны 05-р сар	Нээгдсэн	
69	Зурагтын зам	CU165	2022 оны 05-р сар	Нээгдсэн	
70	Төмөр замын цагдаа	CU213	2022 оны 05-р сар	Нээгдсэн	
71	Эх нялхас салбар	CU215	2022 оны 05-р сар	Нээгдсэн	
72	Ботаник	CU177	2022 оны 05-р сар	Нээгдсэн	
73	Улсын 1-р төв эмнэлэг	CU218	2022 оны 05-р сар	Нээгдсэн	
74	Самбуугийн гудамж	CU214	2022 оны 05-р сар	Нээгдсэн	
75	32-н буудал	CU217	2022 оны 05-р сар	Нээгдсэн	
76	Хоймор оффис	CU216	2022 оны 05-р сар	Нээгдсэн	
77	Нэхмэл хотхон	CU204	2022 оны 05-р сар	Нээгдсэн	
78	Буян Налайх	CU212	2022 оны 05-р сар	Нээгдсэн	
79	10-р хороолол -2	CU219	2022 оны 05-р сар	Нээгдсэн	
80	Премиум Апартмент	CU207		Нээгдээгүй	Цахилгааны техникийн нөхцөл хүлээж байгаа тул түр хойшилсон
81	Намуун зочид буудал	CU221	2022 оны 06-р сар	Нээгдээгүй	

Хавсралт №3

Гэрэгэ Эстимэйт үнэлгээний компанийн ажлууд

Гэрэгэ эстимэйт компани нь дөрвөн компаниийн IPO-д үнэлгээ хийж байсан ба эдгээр компаниудын IPO хийсэн хугацаа, анхны үнэ, одоогийн үнийн мэдээллийг доор харуулав.

1. **Сэнтрал Экспресс Си Ви Эс**

   Анхны үнэ: **208₮**

   Огноо: **2021.11 сар**

   Одоогийн үнэ: **200.38₮ (-3.6%)**

2. **Бодь Даатгал**

   Анхны үнэ: **113₮**

   Огноо: **2021.06 сар**

   Одоогийн үнэ: **132₮ (+16.8%)**

3. **Инвескор ББСБ**

   Анхны үнэ: **1,550-1,750₮**

   Огноо: **2019.06 сар**

   Одоогийн үнэ: **4,464₮ (+170.5%)**

4. **ЛэндМН ББСБ**

   Анхны үнэ: **25₮**

   Огноо: **2021.06 сар**

   Одоогийн үнэ: **34.95₮ (+39.8%)**

Хавсралт №4

Өмнөх ба дараах IPO хийсэн компаниудын үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарцуулалтын төлөвлөгөөний мэдээлэл

Симбол	Компани татан төвлөрүүлэх хөрөнгө	Зарцуулахаар төсөвлөсөн дүн	IPO зардлыг тусгасан эсэх	Хавсралт
BOGD	31,750,000,000	31,750,000,000	Үгүй	**Error! Not a valid bookmark self-reference.**
BODI	Багадаа 3,988,669,214	3,988,669,214	Үгүй	**Error! Reference source not found.**
INV	Дунджаар 18,129,200,000	18,129,200,000	Үгүй	**Error! Reference source not found.**
MFC	8,585,858,960	8,585,858,960	Үгүй	**Error! Reference source not found.**
ADB	Багадаа 4,900,000,000	4,900,000,000	Үгүй	**Error! Reference source not found.**
TUM	10,000,000,000	10,000,000,000	Үгүй	Хавсралт 1
AIC	5,250,000,000	5,250,000,000	Үгүй	**Error! Reference source not found.**
MNDL	5,966,476,800	5,966,476,800	Үгүй	**Error! Reference source not found.**
ERDN	2,560,000,000	2,560,000,000	Үгүй	**Error! Reference source not found.**
MBW	6,431,538,000	6,431,538,000	Үгүй	Хавсралт 2
LEND	5,000,000,000	5,000,000,000	Үгүй	**Error! Reference source not found.**

Богд банкны татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

6.6. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Богд Банк нь олон нийтээс татан төвлөрүүлж буй хөрөнгөөр дунд хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж, банкны үйл ажиллагааг өргөжүүлж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Тус ажлын хүрээнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийж, бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлт болон зээл олголтын үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 30 Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

№	Хөрөнгө оруулалтын төрөл (сая төгрөг)	2021	2022	2023	Нийт	Хувь
1	Технологийн хөрөнгө оруулалт	2,540	7,303	2,858	**12,700**	**40%**
2	Бүтээгдэхүүн үйлчилгээ, хөгжүүлэлт	1,905	3,810	3,810	**9,525**	**30%**
3	Борлуулалтын сувгийн хөгжүүлэлт, сайжруулалт	2,778	3,523	3,224	**9,525**	**30%**
	Нийт	**7,223**	**14,636**	**9,891**	**31,750**	**100%**

Бодь даатгалын татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

2.4. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

2019 -08- 28

Үнэт цаас гаргагч нь 35,297,958 ширхэг хувьцааг нэмж гарган нийтэд санал болгон арилжих ба нэгж хувьцааг 113-135 төгрөгийн үнээр захиалгын бүртгэлийн аргаар санал болгож, хамгийн багадаа 3,988,669,214 төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлнэ. Хувьцаа эзэмшигчдийн борлуулж буй 23,531,974 ширхэг 10%-ийн хувьцааг худалдсан хөрөнгө нь Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхгүй.

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

95% Хөрөнгө оруулалт 3,789,235,753 ₮

5% Технологийн хөгжүүлэлт 199,433,460 ₮

8.7 ҮНЭТ ЦААС ГАРГАН ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Компани нь нийт хувьцааны 15 хувийг буюу 10,759,188 ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгон арилжих замаар дунджаар 18.1 тэрбум төгрөгийн санхүүжилт татахаар төлөвлөсөн. Үнэт цаас гаргагч нь Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй хүрээнд нэмж хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгийг Компанийн үндсэн бүтээгдэхүүн болох зээл олголт, зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 44: Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ	Зарцуулах дүн, сая төгрөг	Эзлэх хувь, %
Бизнесийн том зээл - ААН	1,812.9	10%
Бизнесийн зээл – ЖДҮ эрхлэгч ААН	2,719.4	15%
Бизнесийн зээл – ЖДҮ эрхлэгч иргэд	1,812.9	10%
Хэрэглээний зээл	7,251.7	40%
Автомашины лизингийн зээл	3,625.8	20%
Кредит карт	906.5	5%
Нийт	**18,129.2**	**100%**

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

БҮРТГЭЛ-02

Хүснэгт 22. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	Нийт
Үйлдвэрлэлийн барилгын өргөтгөл	**2,047.5**
Лаборатор	150.0
GMP модуль буюу үйлдвэрлэлийн зохистой дадал	927.5
Агуулахын өргөтгөл	416.0
Давхар хуваалт үндсэн хийц өөрчлөлт, заслын ажлууд	554.0
Тоног төхөөрөмж	**5,038.4**
Ус цэвэрүүлэх систем	148.0
Автомат ус, ундаа, шүүс найрлагын систем	1,454.0
Бүрэн автомат хуванцар сав үлээгч машин	312.0
Халуун болон хүйтэн хуванцар савлагааны машин	362.0
Уутан савлагааны төхөөрөмж	156.0
Хуруу шилэнд савлах төхөөрөмж	147.0
Ургамал хандлагч бүрэн автомат төхөөрөмж	131.0
Тавилга	260.0
Тээвэр болон суурилуулалтын зардал	856.4
Тээврийн хэрэгсэл	495.0
Хар саримс бэлтгэх тоног төхөөрөмж	137.0
Хөлдөөн хатаах тоног төхөөрөмж	580.0
Эргэлтийн хөрөнгө	**1,000.0**
Шинэ технологид хөрөнгө оруулах	**500.0**
НИЙТ	**8,585.9**

Ард Кредитийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

3.4. Үнэт цаасаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

"Ард Кредит ББСБ" ХХК нь нийт хувьцааны 25% буюу 70,000,000 ширхэг хувьцааг нэг бүрийг 70 төгрөг болон түүнээс доошгүй үнээр (70-85 төгрөг) олон нийтэд санал болгох замаар нийт 4.9 тэрбум төгрөг болон түүнээс доошгүй санхүүжилтийг олон нийтээс татан төвлөрүүлнэ. Компани нь хувьцааны борлуулалтаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг үндсэн зээлийн үйлчилгээгээ нэмэгдүүлэх болон шинээр нэвтрүүлж байгаа "Ард" аппликэйшн, хувьцаа барьцаалсан зээлийн үйлчилгээг нэвтрүүлэхэд зарцуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт 64. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ	Зарцуулах дүн сая төгрөг	Эзлэх хувь хувь
Бизнесийн зээл	2,768.5	56.5%
Хэрэглээний зээл	612.5	12.5%
Шуурхай зээл	980.0	20.0%
Кредит карт	367.5	7.5%
Ард	49.0	1.0%
Хувьцаа барьцаалсан зээл	122.5	2.5%
Нийт	4,900.0	100.0%

Хавсралт 1. Түмэн шувуутын татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАДАРГАА	сая.төг	Эзлэх хувь
Өндөглөгчийн 8-р байр	1,249	13%
Өндөг боловсруулах үйлдвэр	1,531	15%
Махны тахианы аж ахуй, тэжээл үйлдвэрлэл	3,928	39%
Сангасны бордооны үйлдвэр	946	10%
Сангасны бордооны байр	705	7%
Усжуулах ХК-д хөрөнгө оруулалт	625	6%
Эргэлтийн хөрөнгө	1,016	10%
НИЙТ	**10,000**	**100%**

Хүснэгт: 15 Хөрөнгө оруулалтын задаргаа

Нийт хөрөнгө оруулалтын 40 хувийг тахианы махны төсөлд зарцуулах бөгөөд улмаар цаашдын бизнесийн гол шугамыг нээхээр төлөвлөж байна. Мөн өндөгний үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өндөгний өртөгийг бууруулахад нийт хөрөнгө оруулалтын 28 хувь буюу 2.8 тэрбум төгрөгийг зарцуулах юм. Уг ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

Ард даатгалын татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

2.6. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагчийн МХБ-д бүртгүүлж олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах нэн тэргүүний зорилго бол СЗХ-ны "Даатгалын компанийн дүрмийн сангийн доод

126

СЗХ
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 31

ARD ДААТГАЛ

000012

Монголын Хөрөнгө
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
Үнэт цаасны танилцуулга

хэмжээг шинэчлэн тогтоох" тухай тогтоолын дагуу дүрмийн сангаа нэмэгдүүлэх шаардлагатай юм.

Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 355 дугаар тогтоолоор "Ердийн даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээ 5 тэрбум байна" гэж тогтоон 2016 оны 12 сарын 31-ний өдрийн дотор биелүүлж ажиллахыг ердийн даатгалын компаниудад үүрэг болгосон. СЗХ нь улс орны эдийн засаг, бизнесийн орчин нөхцөл, даатгалын компаниудын санхүү, төлбөрийн чадварын байдлыг харгалзан 236 тоот тогтоолоор хэрэгжиж эхлэх хугацааг 2018 оны 06 сарын 30-ны өдөр болгон сунгасан.

Иймд үнэт цаас гаргагч нь 7,500,000 ширхэг хувьцаа нэмж гаргаснаар СЗХ-ны дүрмийн сангийн шаардлагыг хангахаар байна.

Үнэт цаас гаргагч нь олон нийтээс татан төвлөрүүлэхээр тооцоолсон 5.25 тэрбум төгрөгийг СЗХ-ны холбогдох журмын дагуу хадгаламж, ББСБ-ын итгэлцэл, ЗГҮЦ, МХБ дээрх үнэт цаас, компанийн бонд, үл хөдлөх хөрөнгө, хөрөнгө оруулалтын сан зэрэг хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн.

Үнэт цаас гаргагч нь дараагийн 5 жилийн хугацаанд дараах санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн:

Хүснэгт 63. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт /сая.төг/

№	Хөрөнгө оруулалтууд	2017	БТ2018	БТ2019	БТ2020	БТ2021	БТ2022
1	Хадгаламж	2,600.00	5,000.00	5,600.00	7,000.00	8,500.00	10,500.00
2	ББСБ итгэлцэл	60.00	550.00	750.00	1,300.00	2,300.00	3,500.00
3	ЗГҮЦ	1,386.40		300.00	1,000.00	1,200.00	1,000.00
4	МХБ-ны дэлгэх үнэт цаас	639.40	2,700.00	3,000.00	3,400.00	4,400.00	5,000.00

5	Компанийн бонд	1,097.70	1,500.00	1,800.00	2,400.00	3,500.00	4,500.00
6	Үл хөдлөх хөрөнгө	1,800.00	1,800.00	1,800.00	800.00		3,000.00
7	Хөрөнгө оруулалтын сан		1,800.00	2,000.00	2,600.00	3,200.00	4,000.00
Нийт хөрөнгө оруулалт		**7,583.50**	**13,350.00**	**15,250.00**	**18,500.00**	**23,100.00**	**31,500.00**

Нийт хөрөнгө оруулалтын дунджаар 35 хувийг хөрөнгийн зах зээлд, 36.4 хувийг банкны салбарт, 7.4 хувийг банк бус санхүүгийн салбарт, үлдэх хувийг үл хөдлөх хөрөнгө болон хөрөнгө оруулалтын санд байршуулахаар төлөвлөжээ.

Мандал даатгалын татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

3.7. Үнэт цаасаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд нээлттэй хүрээнд нэг бүрийн 4,800 төгрөгийн үнэтэй 1,560,754 ширхэг энгийн хувьцаа санал болгох замаар нийт 7,491,619,200 төгрөгийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлнэ. Үүнээс, 1,243,016 ширхэг энгийн хувьцаа санал болгох замаар татан төвлөрүүлсэн хөрөнгө буюу 5,966,476,800 төгрөг нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх бол үлдсэн "Юу Эм Си Капитал" ХХК-ийн эзэмшлийн 317,738 ширхэг хувьцааг худалдсан хөрөнгө буюу 1,525,142,400 төгрөг нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхгүй юм.

Үнэт цаас гаргагч нь энэхүү нэмэлт мөнгөн хөрөнгө болох 5,966,476,800 төгрөгийг СЗХ-ны 2013 оны 12 сарын 12-ны өдрийн 498 тоот тогтоолоор батлагдсан "Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага"-ын дагуу зарцуулахаар төлөвлөж байна.

Аливаа даатгалын байгууллага нь хувь нийлүүлсэн хөрөнгө/мөнгөн хөрөнгөө нэмэгдүүлэхэд дараах эрэг нөлөөг авчирдаг. Үүнд:

- **Зах зээлд эзлэх байр суурь өсөх:** Хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдсэнээр үнэт цаас гаргагч нь өндөр дүн бүхий хохирлын эрсдэлийг даатгах чадвартай болж зах зээлд эзлэх байр суурыа нэмэгдүүлэх боломжтой ба энэ нь нийт хураамжийн орлогын өсөлтөд эергээр нөлөөлнө.

- **Орлогод тооцсон хураамж өсөх:** Даатгалын тухай хуульд даатгалын байгууллага нь өөрийн хөрөнгөөс давсан дүнгийн эрсдэл даахыг хориглосон байдаг. Иймд, даатгалын байгууллагууд нь өөрийн хөрөнгөөс давсан эрсдэлийг давхар даатгагчид шилжүүлж, давхар даатгалын хураамж төлдөг ба энэ нь ашигт ажиллагааг бууруулдаг.

- Үнэт цаас гаргагчийн хувьд өөрийн эрсдэл даах чадварыг 50,000 ам.доллар буюу 122 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд үүнээс давсан хэсгийг трийти болон факултатив давхар даатгалаар эрсдэлийг шилжүүлдэг. 2016 онд нийт хураамжийн орлогын 57%, 2017 онд 50%-ийг давхар даатгалд шилжүүлсэн нь сайжирсан үзүүлэлт боловч дахин сайжруулах орон зай байгааг харуулж байна. Тухайлбал, 2017 оны 07 сарын 01-ны өдрөөс эхэлсэн трийти давхар даатгалын нөхцөлийн өөрчлөлт нь богино хугацаанд компанийн ашигт ажиллагаанд эергээр нөлөөлсөн ба хуучин нөхцөлийн дагуу цэвэр ашиг 733 сая төгрөг гарах байсан бол Excess of Loss нөхцөл рүү шилжсэнээр цэвэр ашиг 1.1 тэрбум төгрөг болж 324 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Компанийн мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлж эрсдэл даах чадварыг 3 дахин буюу 150,000 ам доллар (370 сая төгрөг) хүргэвэл цэвэр хураамжийн орлогод 20% хувийн эерэг нөлөөтэй гэж үнэт цаас гаргагч тооцоолжээ.

- **Хөрөнгө оруулалтын хэмжээ өсөх:** Мөнгөн хөрөнгийг 5,966,476,800 төгрөгөөр нэмэгдүүлснээр хөрөнгө оруулалтын орлого дунджаар 46%-иар өсгөх боломжтой ба энэ нь ашигт ажиллагаанд нөлөөлөх гол хүчин зүйл болох юм.

Эрдэнэ ресурсын татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

2.5.2 Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Компани нь татан төвлөрүүлэх хөрөнгийг 2018 онд хийх хайгуулын өрөмдлөгийн ажилд зарцуулах төлөвлөгөөтэй байна. МХБ-ээс татан төвлөрүүлэх хөрөнгө болон компанийн эргэлтийн хөрөнгөөс гадна Компани нь 2018 оны төсөвлөсөн зардлыг үнэт цаас гарган санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байна.

Хавсралт 2. Монгол базальтын татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

2.2.2 Үнэт цаасаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь дунд хугацааны буюу 2018-2020 оны бизнес төлөвлөгөөндөө чулуун хөвөн үйлдвэрлэлийг илүү боловсронгуй болгох, олон улсад экспортлоход чанарын шаардлага хангасан нарийн ширхэг бүхий хөвөн үйлдвэрлэхээр зорин ажиллаж байна. Бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд компанид техник, технологийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд үүнд цахилгаан зуух, шүршдэг базальт технологийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, базальт карьерийн аж ахуйг хөгжүүлэх ажлууд багтаж байна. Эдгээр ажлуудад шаардлагатай хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь 6.4 тэрбум төгрөг бөгөөд үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаа гаргаж энэхүү хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа болно.

Хөрөнгө оруулалтын хэмжээ			
Д/д	Зориулалт	Дүн (төгрөг)	Хувь
1	Чулуун хөвөнгийн үйлдвэрийн өргөтгөл	2,525,000,000	39.3%
2	Цахилгааны дэд станц	1,100,000,000	17.1%
3	Үйлдвэрийн барилга	680,000,000	10.6%
4	Үйлдвэрт ажиллах машин механизм	330,000,000	5.1%
5	Базальт чулуу карьерийн аж ахуйн тоног төхөөрөмж	490,976,700	7.6%
6	Базальт чулуу карьерийн аж ахуйн машин механизм	210,000,000	3.3%
7	Түүхий эдийн нөөц	599,013,800	9.3%
8	Эх үүсвэрийн эргэн төлөлт	496,547,500	7.7%
НИЙТ ДҮН		**6,431,538,000**	**100%**

Хүснэгт 57 Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

ЛэндМН-ийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

3.2 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

ЛэндМН ББСБ ХХК-ийн 25 % буюу 200,000,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган МХБ-ээр дамжуулан арилжих ба хувьцааны борлуулалтаас олох орлогыг компани үндсэн бүтээгдэхүүний санхүүжилтийн эх үүсвэрт зарцуулна.

Нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ: 5,000,000,000 төгрөг

Олон нийтээс татан төвлөрүүлэх 5 тэрбум төгрөгийг 100% үндсэн бүтээгдэхүүний зээлийн санхүүжилтийн эх үүсвэрт ашиглан зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлнэ.